



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Есөнбулаг сум,  
Говь-Алтай аймаг, 82099, Утас/Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn,  
Цахим хаяг: www.audit.mn

2024. 11. 20

№ 409

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АЙМГИЙН ЗАСАГ  
ДАРГА Г.ЧИНБАТ ТАНАА**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/162 дугаар тушаалыг тус тус үндэслэн "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан шийдвэрийг хүргүүллээ.

Аудитаар өгсөн санал, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан, биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Хавсралт ... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР *Г.Гүнжидмаа* Г.ГҮНЖИДМАА



07730872

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ  
ҮР НӨЛӨӨ

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНД ТУХАЙН АЛБАН  
ТУШААЛЫН СУЛ ОРОН ТООНД АЖИЛЛАХ МЭРГЭЖЛИЙН  
БОЛОВСОН ХҮЧИН ДУТАГДАЛТАЙ БАЙНА.

АУДИТЫН КОД: ГАА-2024/19-6-ШТА-ГА

Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын  
газар

Дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа  
Утас: 70483413

Цахим хаяг: Gunjidmaag@audit.gov.mn  
Аудитын менежер Д.Эрдэнэчимэг  
Утас: 70484055

Цахим хаяг: Erdenechimegd@audit.gov.mn  
Ахлах аудитор Б.Цэцэгмаа

Цахим хаяг: Tsetsegmaab@audit.gov.mn  
Аудитор С.Санчирмаа

Цахим хаяг: Sanchirmaas@audit.gov.mn  
Аудитор Б.Мөнхболд

Цахим хаяг: Munkhboldb@audit.gov.mn

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

## Агуулга

Товчилсон үг.....	2
Хүснэгтийн товъёг.....	2
Дүрслэлийн товъёг.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	3
Аудитаар илрүүлсэн зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж байна.....	23
1. Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт нийцүүлсэн төрийн байгууллагын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөг боловсруулж, батлаагүй байна.....	23
2. Бодлогын баримт бичиг, төрийн байгууллагын чиг үүрэгт хяналт-шинжилгээ хэрэгжүүлээгүй байна.....	23
3. Аймаг, сумын ЗДТГ-ын бүтэц орон тоог Засгийн газраас тогтоосон хязгаараас илүү тоогоор баталсан байна.....	23
4. Аймгийн хэмжээнд төрийн улс төрийн болон төрийн үйлчилгээний албан тушаалын тодорхойлолт баталж мөрдүүлээгүй, нийт албан тушаалын тодорхойлолтод хяналт-шинжилгээ хийгээгүй байна.....	23
5. Орон нутгийн нэмэгдэл олгох хувь хэмжээг харилцан адилгүй тогтоосон, зарим төрийн албан хаагчид тус нэмэгдлийг олгохгүй байна.....	23
6. Төрийн захиргааны 35 байгууллагын 93 төрийн жинхэнэ албан тушаал, 14 байгууллагын 71 төрийн үйлчилгээний нийт 164 сул орон тоо байна.....	23
7. Сул орон тоог нийтэд зарлахгүй байх, хууль зөрчин түр томилгоо хийсний дараа зөрчлийг арилгах арга хэмжээ авч байгаа байдал нийтлэг бий болсон байна.....	23
8. “Шүүр” ажиллагааны хүрээнд илэрсэн 22 байгууллагын албан тушаалын томилгоотой холбоотой 31 зөрчил арилаагүй байна.....	23
<b>ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ:</b> .....	25

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

## Товчилсон үг

№	Тайлбар
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ГНАГ	Гүйцэтгэл-нийцлийн аудитын газар
УИХ	Улсын Их Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ҮСХ	Төрийн албаны зөвлөл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчийн Хурал
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч

## Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт № 1	Дунд хугацааны хөтөлбөрт тусгасан арга хэмжээний жагсаалт	6
Хүснэгт № 2	ИТХ-ын ажлын албаны батлагдсан бүтэц, орон тооны хязгаар	7
Хүснэгт № 3	Аймгийн ЗДТГ-ын батлагдсан бүтэц, орон тооны хязгаар	8
Хүснэгт № 4	Сумын ЗДТГ-ын батлагдсан бүтэц, орон тооны хязгаар	8
Хүснэгт № 5	Говь-Алтай аймаг дахь төрийн албан хаагчдын тоо	9
Хүснэгт № 6	Хэрэгжүүлэгч агентлагуудын бүтцийн өөрчлөлт	
Хүснэгт № 7	Аймаг, сумдын ЗДТГ-ын батлагдсан орон тоо	11
Хүснэгт № 8	Хүчингүй болгосон захирамж	14
Хүснэгт № 9	Удирдах ажилтны жендерийн байдал	19
Хүснэгт № 10	Төрийн албан хаагчдын жендерийн байдал	19
Хүснэгт № 11	Авлигын эсрэг хөтөлбөрийн зорилт	21

## Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл № 1	"Алсын хараа 2050"	5
Дүрслэл № 2	Хүний нөөцийн программын бүтэц	16

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

**Аудитын үндэслэл, бүрэн эрх**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл**  
Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны "Аудитын сэдэв батлах тухай" 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/162 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг үндэслэн "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө"-д гүйцэтгэлийн аудит хийлээ.

**Аудитын зорилт**

"Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө"-д аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөл болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд тус аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрхзүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрэн бүрдсэн эсэх
- ✓ Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх

**Аудитын хамрах хүрээ**

Аудитад аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагаа, аймгийн ОНТЕЗ-ын нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг нутгийн өөрөө удирдах, төрийн захиргааны болон ААТҮГ-ын хүний нөөцийн бодлого тогтолцоо, батлагдсан бүтцийн хөдөлгөөн өөрчлөлт, төрийн албанд гарсан сул орон тоог нөхөж буй байдал, төрийн албан хаагчийн тогтвор суурьшил, нийгмийн баталгаагаар хангагдсан байдал, эрх бүхий байгууллагаас дээр дурдсан асуудлын хүрээнд хийсэн хяналт үнэлгээ хийсэн байдлыг хамруулан аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөл болон холбогдох төрийн байгууллагын хүний нөөцтэй холбоотой 2012-2024 оны баримт материалыг хамруулан гүйцэтгэлээ.

**Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит. Тулгуур зарчим", MNS 6817-5:2020 "Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим", MNS 6817-7:2020 "Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит", MNS 6817-8:2020 "Төрийн аудит. Нийцлийн аудит"-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан "Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал"-ыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

**Аудитын бүрэлдэхүүн, хугацаа**

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Г.Гүнжидмаа удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Цэцэгмаа, аудитор Б.Мөнхболд, С.Санчирмаа нар батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын гүйцэтгэх үе шатны талбарын ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 03-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдөр хүртэл гүйцэтгэж, дүгнэлт зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагаас гаргасан саналыг авч

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

Хүндрэл  
бэрхшээл

хэлэлцэн аудитын тайланг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

ОНТЕЗ-ын харьяаны ихэнх байгууллагад хүний нөөцийн орон тооны ажилтан байхгүй байдал, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл хангалтгүй байдал, тухайн байгууллагад аудит хамрах хугацаанд бүтэн ажилласан хүний нөөц байхгүй байдлаас шалтгаалан аудитад шаардлагатай баримт материал гаргаж өгөх процесс удаашралтай байлаа.

### ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийг анх 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлан, 1995 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж, хуульд нийтдээ 44 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулжээ.

УИХ-аас 1996 онд "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлогын тухай" 38 дугаар тогтоолыг баталсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог 2016-2024 онд нийт 6 удаа, сумын Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоог 2012-2024 онд 5 удаа шинэчлэн тогтоосон байна.

Говь-Алтай аймаг 2013 онд 52,961 хүн амтай байсан бол 2023 оны байдлаар 57,328 болж 8.2 хувиар өссөн.

Төрийн албаны зөвлөлөөс гаргасан мэдээллээр 2013 онд Говь-Алтай аймагт төрийн 159 байгууллагад 3,724 албан хаагч, 2023 оны байдлаар 174 байгууллагад 4,793 албан хаагч ажиллаж байна.

Сүүлийн 10 жилийн байдлаар авч үзвэл төрийн байгууллага 15, төрийн албанд ажиллагсдын тоо 1,069-өөр тус тус нэмэгджээ.

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

## 1.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХЗҮЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО БҮРЭН БҮРДСЭН ҮҮ?

Төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг Монгол Улсын үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

**1.1 Төрийн байгууллагуудын хүний нөөцийн асуудлыг зохицуулж буй хууль тогтоомж, баримталж буй бодлогын зорилт арга хэмжээ нь нэгдмэл, харилцан уялдаатай, бүх талын оролцоог хангаж чадаж байна уу?**

Засгийн газраас холбогдох хууль тогтоомжийн дагуу 2013-2024 онд нийт 9 удаагийн тогтоолоор аймаг, сумын ЗДТГ-ын орон тооны дээд хязгаарыг тогтоож, эрхлэх асуудлын хүрээнд харьяалах агентлагуудыг баталжээ.


Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, засаглалтай холбогдох 20 зорилт, 162 арга хэмжээг 3 үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төрийн байгууллагуудын хүний нөөцийн асуудлыг зохицуулж буй хууль тогтоомжид нийцүүлэн эрх зүйн болон Засгийн газар, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны чиглэл, бүтэц тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг төлөвлөж, ухаалаг төрийн үйлчилгээ, цахим засаглалыг хөгжүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

**1.1.1 Төрийн байгууллагын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц нь Монгол Улсын дунд, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцэж байна уу?**

Монгол Улсын хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, засаглалтай холбогдох шат дараалсан арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Тухайлбал:

Дүрслэл №1. "Алсын хараа 2050"-д монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг засаглал тогтоож захиргааны оновчтой бүтэц бүхий төрийг төлөвшүүлэх зорилтын хүрээнд дараах чиглэлээр үе шаттай бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр тусгасан байна.



Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2<sup>1</sup>-д заасан урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд төрийн байгууллагын үйл ажиллагааг сайн засаглалтай, монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг, тогтвортой засаглал тогтоож, оновчтой бүтэц бүхий цахим технологид тулгуурласан иргэн төвтэй, шударга ёсны тогтолцоо төлөвшсэн авлигагүй улс болохыг зорьсон байна.

<sup>1</sup> 2.30 хүртэл жилийн хугацаанд хэрэгжүүлэх "Алсын хараа" нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг байна.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

### Дунд хугацааны бодлогын баримт бичиг:

Засгийн газрын 2012 оны 37, 2016 оны 45, 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-т нийцүүлэн аймгийн ИТХ-ын 2017 оны 35, 2020 оны 11 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус баталсан байна. Дээрх бодлогын баримт бичгүүдэд төрийн албаны хүний нөөц, засаглалтай холбоотой дараах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

#### Хүснэгт №1. Дунд хугацааны хөтөлбөрт тусгасан арга хэмжээний жагсаалт

№	Хугацаа	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр	Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
1	2012-2016 он	Төр засгийг иргэдэд нээлттэй, тунгалаг болгох цогц арга хэмжээ авах.	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг жигдрүүлж үйлчилгээг шуурхай хүргэнэ.
		Төрийн албыг нийтийн алба болгон өөрчлөх 2012-2016 Нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлснээр иргэн зөвхөн нэг цонхоор, нийтийн албан хаагчтай харьцах зарчмыг тогтоож, бусад шат дамжлагад төрийн байгууллагууд хоорондоо харьцах замаар иргэдэд үйлчлэх. Цахим засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлэх.	
2	2016-2020 он	Төрийн байгууллагуудын ажил, үүргийн давхардлыг арилгах, нэгтгэх замаар яам, агентлаг, төсвийн байгууллагуудын тоог цөөлж, оновчтой бүтцийг бий болгоно.	Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийнэ.
		Төрийн албаны тогтвортой байдлыг баталгаажуулж, төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх танхимын болон зайн сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлж, төрийн албаны мэргэшсэн, чадварлаг байх нөхцөлийг бүрдүүлнэ.	Төрийн албан хаагчдыг давтан сургалтад хамруулж чадавхжуулна.
		Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчныг бүрдүүлж, иргэдийн эрхийг баталгаажуулна.	Төрийн албаны боловсон хүчний бодлогыг боловсруулна.
3	2020-2024 он	Цахим хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, удирдлагаар хангаж, төрийн үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн цаг хугацаа, зардлыг хэмнэнэ.	Төрийн үйлчилгээний шат дамжлагыг цөөрүүлэн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор “Цахим-Алтай” арга хэмжээ хэрэгжүүлж, үйлчилгээний нэгдсэн төвөөр үзүүлэх, үйлчилгээний тоо, төрлийг нэмэгдүүлнэ.
		Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно.	Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана

Хөгжлийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг, тогтвортой засаглалыг бий болгох зорилтын хүрээнд төрийн албаны тогтвортой байдлыг баталгаажуулах, мэргэшсэн чадварлаг төрийн албан хаагчдыг бэлтгэх, оновчтой уялдаатай бүтцийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг тусгасан байна.

#### Төрийн байгууллагын үйл ажиллагааны стратеги:

УИХ-ын 2007 оны 186 дугаар тогтоолоор “Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги”-ийн баримт бичгийг баталж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн албаны төв байгууллагад даалгасан байна.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 53 дугаар зүйлийн 53.1<sup>2</sup>-д төсвийн ерөнхийлөн захирагч нь хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгохыг заасан.

Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам"-ын 2.1<sup>3</sup>-д "стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн баримт бичиг бөгөөд стратеги төлөвлөгөө батлагдсанаас хойш хоёр сарын дотор салбарын, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн, байгууллагын стратеги төлөвлөгөөг тус тус дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулна" гэж заасан байна.

Дээрх журмын дагуу аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөгүүгээс орон нутагт төрийн албаны хүний нөөцийн нэгдсэн бодлого тогтолцооны баримт бичиггүй байна.

### 1.1.2 Батлагдсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийг төрийн байгууллагууд мөрдөн ажиллаж байна уу?

Засгийн газраас холбогдох хууль тогтоомжийн дагуу шат шатны ИТХ, аймаг, сумын ЗДТГ-ын орон тооны дээд хязгаарыг тогтоож эрхлэх асуудлын хүрээний агентлагуудыг баталдаг байна.

Хүснэгт №2. ИТХ-ын ажлын албаны батлагдсан бүтэц, орон тооны хязгаар

№	Нэр	ЗГ-ын 2021 оны 376 дугаар тогтоол
1	Аймгийн ИТХ-ын Ажлын алба	12
2	6000-аас дээш хүн амтай сумын ИТХ-ын Ажлын алба	4
3	Сумдын ИТХ-ын Ажлын алба	3

Хүснэгт №3. Аймгийн ЗДТГ-ын батлагдсан бүтэц, орон тооны хязгаар

№	Нэр	Засгийн газрын		
		2008 оны 67 дугаар тогтоол	2016 оны 9 дүгээр тогтоол	2021 оны 377 дугаар тогтоол
1	Аймгийн ЗДТГ	41 хүртэл	41 хүртэл	55 хүртэл

Хүснэгт №4. Сумын ЗДТГ-ын батлагдсан бүтэц, орон тооны хязгаар

№	Нэр	ЗГ-ын 2009 оны 13 дугаар тогтоол
1	1501-3000 хүртэл хүн амтай сумд	15
2	3001-5000 хүртэл хүн амтай сумд	16
3	10001-20000 хүртэл хүн амтай сумд	21

Говь-Алтай аймгийн сумдын хүн амын тоо 2013-2023 онд дээрх хязгаарт багтаж байгаа бол аймгийн төвийн хүн амын тоо 2013 оноос 7.0 хувиар өссөн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын зохион байгуулалтын бүтцэд 3 удаагийн өөрчлөлт орсон ба одоо аймгийн ЗДТГ 6 хэлтэс, 1 штабтай үйл ажиллагаа явуулж байна.

<sup>2</sup> 53.1.Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг харууцан зохион байгуулна.

<sup>3</sup> 2.1. Стратеги төлөвлөгөө нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө болон аймаг, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд арга хэмжээний төлөвлөгөө батлагдсанаас хойш хоёр сарын дотор салбарын, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн, байгууллагын стратеги төлөвлөгөөг тус тус дөрвөн жилийн хугацаатайгаар боловсруулна.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

Засгийн газрын бүтэц, орон тооны хязгаар баталсан тогтоолын дагуу аймгийн ЗДТГ-ын эрхлэх асуудлын хүрээнд 2013-2023 оны хооронд 23-25 агентлагтайгаар үйл ажиллагаагаа хэрэгжүүлэн ажилласан байна.

**Дүгнэлт:** Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт нийцүүлсэн төрийн байгууллагын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, хөтөлбөрийг батлаагүй байна.

**1.1.3 Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх олон талын уялдаа холбоо хангагдаж, биелэлтэд ахиц, дэвшил гарсан уу?**

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1<sup>4</sup> -д заасны дагуу хөгжлийн бодлого төлөвлөлтөд нэгдмэл, цогц, харилцан уялдаатай, тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх зарчмуудыг баримтлахаар тусгасан.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд 2013-2024 онд тусгасан оновчтой бүтэц, иргэндээ үйлчилдэг ухаалаг төрийн үйлчилгээ, аймгийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг ажил, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, цахим засаглалыг хөгжүүлэх зорилт нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэлд 2012-2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан цахим засаглал хөтөлбөр, нэг цонжны үйлчилгээг нэвтрүүлэх, төрийн албаны тогтвортой байдлыг баталгаажуулах, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй, хүнд суртлаас ангид байх эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилт болон, "Алсын хараа-2050" хөгжлийн баримт бичигтэй уялдсан байна.

Тухайлбал улсын хэмжээнд хэрэгжиж буй дараах арга хэмжээ нь бодлогын баримт бичгийн биелэлтэд тодорхой ахиц, дэвшил бий болгосон байна. Үүнд:

1. Төрийн үйлчилгээг иргэд өөрт хамгийн ойр байрлаж буй "ТҮЦ" машинаас авах нөхцөл боломжийг бүрдүүлсэн,
2. Цахим мэдээлэл солилцооны "ХУР" болон дан системийг хөгжүүлснээр иргэд мэдээллийг орон зайнаас үл хамааран цаг алдалгүй, хурдан шуурхай авах нөхцөл бий болсон.

**Дүгнэлт:** Бодлогын зорилтыг хэрэгжүүлэх олон талын уялдаа холбоо хангагдаж, ухаалаг төрийн үйлчилгээ, цахим засаглал арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

**1.1.4 Төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-үнэлгээ хийж, үр нөлөөг тооцож байна уу?**

Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоол<sup>5</sup>, 2017 оны 89 дүгээр тогтоол<sup>6</sup>, 2020 оны 206 дугаар тогтоолоор "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх нийтлэг журам"-ыг баталсан.

Монгол Улсын хөгжлийн бодлогын урт, дунд хугацааны баримт бичгүүдэд төрийн албаны хүний нөөц, засаглалын чиглэлтэй холбоотой тусгасан зорилт, арга хэмжээг аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс чиг үүргийн дагуу нутгийн захиргааны байгууллага, харьяа хэлтэс, нэгжээс ирүүлсэн тайланг нэгтгэн Засгийн газарт хүргүүлдэг байна.

<sup>4</sup> 5.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд дараах зарчмыг баримтална:

5.1.3. нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;

5.1.4. тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх;

<sup>5</sup> 2013 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 388 дугаар тогтоолоор баталсан журмыг 2017 оны 89 дүгээр тогтоол батлагдсанаар хүчингүй болсон.

<sup>6</sup> 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 206 дугаар тогтоолоор журам шинэчлэн батлагдсанаар хүчингүй болсон.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

Бодлогын баримт бичиг, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хэрэгжүүлж байгаа хэдий ч үр дүнг тооцож, үнэлж дүгнэдэггүй байна.

### 1.2 Төрийн байгууллагын хүний нөөцийн тогтолцоо нь төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд чиглэгдэж байна уу?

Төрийн байгууллагын хүний нөөцийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг тогтолцоонд нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, цаг үеийн нөхцөл байдал, хүн амын өсөлтөөс шалтгаалж тухай бүрд өөрчлөлт оруулж байна.

#### 1.2.1 Төрийн байгууллагын хүний нөөц нь хүрэлцээтэй байна уу?

Төрийн албаны зөвлөлөөс гаргасан төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлээр 2013 онд төрийн 159 байгууллага 3,724 албан хаагч байна. Харин 2023 оны байдлаар төрийн 174 байгууллагад 4,793 албан хаагч байна. Сүүлийн 10 жилийн байдлаар авч үзвэл төрийн захиргааны бүтцээр байгууллагын тоо 15, төрийн албанд ажиллагсад 1,069 болж нэмэгджээ.

Хүснэгт №5. Говь-Алтай аймаг дахь төрийн албан хаагчдын тоо

Он	Хүн амын тоо	Байгууллагын тоо	Төрийн албан хаагчийн тоо
2013	52,961	159	3724
2014	56,698	167	4243
2015	56,018	170	4282
2016	56,694	167	4276
2017	57,440	170	4316
2018	58,280	170	4279
2019	57,479	172	4143
2020	58,343	172	4561
2021	58,735	171	4652
2022	58,257	173	4873
2023	57,328	174	4793

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийг баталсан тогтоолуудыг харьцуулахад 2012 оноос хойш зарим хэрэгжүүлэгч агентлагуудын бүтэц, нэршил дараах байдлаар өөрчлөгдсөн байна.

Хүснэгт №6. Хэрэгжүүлэгч агентлагуудын бүтцийн өөрчлөлт

2012 он	2013-2016 он	2017-2024 он
Татварын хэлтэс		Татварын газар (2024 он)
Нийгмийн даатгалын хэлтэс		Нийгмийн даатгалын газар (2024 он)
Хүүхдийн төлөө хэлтэс	Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтэс	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (2017-2023 он), Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар (2024)

Мөн дараах хэрэгжүүлэгч агентлагуудын нэршлийг солих, бүтцэд өөрчлөлт оруулахаас гадна татан буулгах, нэгтгэх байдлаар тогтолцоог өөрчилсөн байна.

1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс (2012-2014 он), Нийгмийн халамжийн хэлтэс (2014-2016 он), Хөдөлмөр эрхлэлтийн хэлтэс (2014-2016 он)-ийг нэгтгэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (2016-2023 он) зохион байгуулалтад орсон.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

2. Мэргэжлийн хяналтын газар 2022 онд татан буугдаж ажиллагсдыг чиг үүргийг хэрэгжүүлдэг агентлагуудад тараан байршуулсан.
3. Хүнс, хөдөө аж ахуйн газрын харьяанаас Мал эмнэлгийн газар салж бие даасан агентлаг болсон.
4. Орон нутгийн өмчийн газрын харьяанаас Худалдан авах ажиллагааны газар салж бие даасан агентлаг болсон.

Төрийн байгууллагуудын бүтэц, орон тоог батлахдаа тухай бүрд нэршил, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж байгаа нь бодлого чиглэл алдагдах, албан хаагчийн тогтвор суурьшилгүй байдлыг бий болгож байна. (Хавсралт №1)

### 1.2.2 Төрийн байгууллагын үйлчилгээ нь иргэдэд ил тод нээлттэй байна уу?

Аймгийн ЗДТГ-аас нутгийн захиргааны байгууллагын үзүүлж буй төрийн үйлчилгээг шинэ шатанд гаргах, иргэдэд хүрч үйлчлэх, санал гомдлыг шийдвэрлэх зорилгоор 2012 оноос 3-5 байгууллагын төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд нэг цэгээр хүргэх зорилгоор “Нэг цэг”-ийн үйлчилгээний төвийг байгуулж ажиллаж байна.

Үүнээс гадна [www.70481111.mn](http://www.70481111.mn) иргэдийн өргөдөл гомдлыг хүлээн авах операторыг 2017 оноос ажиллуулж байна.

Мөн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны харьяа Төрийн цахим үйлчилгээний хэлтсийг 2023 онд шинээр байгуулан орон нутагт үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх бүтцийн нэгжүүд 56 төрийн байгууллагын 785 төрлийн цахим үйлчилгээг үзүүлж байна.

Төрийн бодлого, чиглэлийг сум, багийн иргэдэд хүргэх, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг танилцуулах, орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал авах, иргэдийн сэтгэгдлийг сонсож, тусгах, иргэд малчдад төрийн үйлчилгээг хүртээмжтэй, шуурхай хүргэх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг, төрийн 17 байгууллага 5,000 орчим км зам туулан, аймгийн 18 сум, 2 тосгон, 88 багт 35 удаагийн уулзалт зохион байгуулж нийт 9,800 гаруй иргэнд хүрч үйлчилсэн талаар аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд тайлагнасан байна.

Дүгнэлт: Төрийн байгууллагын үйлчилгээг иргэн хуулийн этгээдэд нээлттэй, ил тод байх зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

### 1.3 Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлага үр дүнтэй байна уу?

Засгийн газраас холбогдох хууль тогтоомжийн дагуу шат шатны ИТХ, аймаг, сумын ЗДТГ-ын орон тооны дээд хязгаарыг 5 удаа тогтоож, 8 удаагийн өөрчлөлт оруулсан байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны бүтэц, орон тоог 18-аар тогтоосон нь Засгийн газрын тогтоосон хязгаараас 6 орон тоогоор нэмэгдүүлэн баталжээ.

Аймгийн Засаг дарга аймаг, сумдын ЗДТГ-ын бүтэц, орон тоог Засгийн газраас баталсан орон тооны хязгаараас 4-12 орон тоогоор нэмэгдүүлэн баталсан байна.

Хүснэгт №7. Аймаг, сумдын ЗДТГ-ын батлагдсан орон тоо

№	Засаг захиргааны нэгжийн нэр	Орон тооны хязгаар	Баталсан орон тоо	
			Үндсэн	Гэрээт
1	Говь-Алтай аймгийн ЗДТГ	55	55	12
2	Есөнбулаг сумын ЗДТГ	21	22	14
3	Алтай сумын ЗДТГ	15	16	4
4	Баян-Уул сумын ЗДТГ	16	18	2

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

5	Бигэр сумын ЗДТГ	15	16	4
6	Бугат сумын ЗДТГ	15	16	4
7	Дарви сумын ЗДТГ	15	16	4
8	Дэлгэр сумын ЗДТГ	16	18	2
9	Жаргалан сумын ЗДТГ	15	16	4
10	Тайшир сумын ЗДТГ	15	16	4
11	Тонхил сумын ЗДТГ	15	16	4
12	Төгрөг сумын ЗДТГ	15	16	4
13	Халиун сумын ЗДТГ	15	16	4
14	Хөхморьт сумын ЗДТГ	15	16	4
15	Цогт сумын ЗДТГ	16	18	2
16	Цээл сумын ЗДТГ	15	16	4
17	Чандмань сумын ЗДТГ	15	16	4
18	Шарга сумын ЗДТГ	15	16	4
19	Эрдэнэ сумын ЗДТГ	15	16	4

Гэрээт ажилтанд сумдын цэвэрлэх байгууламж хариуцсан ажилтан 2, Есөнбулаг, Баян-Уул, Дэлгэр, Цогт сумаас бусад сумдын ЗДТГ-ын жолооч 1, үйлчлэгч 1 ажилтан багтаж байна.

Аймгийн ЗДТГ-т Төрийн архивын шинэ байр ашиглалтад орсонтой холбоотойгоор тус байрны үйлчлэгч, жижүүр нийт 6, Төрийн үйлчилгээ мэдээллийн төвийн ажилтан 2, үндэсний бичгийн ажилтан 1, аймгийн Засаг даргын туслах 1, аймгийн Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч 2 орон тоо багтаж байна.

Сумын ЗДТГ-ын 2012-2023 онд баталсан бүтэц, тухайн онуудад ажилласан байдлаас үзэхэд 2023 онд шинэчлэн баталсан бүтэцэд шинээр нэмэгдсэн зарим орон тоо төдийлөн хэрэгцээ шаардлагагүй байна. Үүнд:

- ✓ Нийтийн биеийн тамир эрүүл мэндийн ажил хариуцсан арга зүйч
- ✓ Хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан хариуцсан мэргэжилтэн
- ✓ Мэдээллийн технологи, олон нийт хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан
- ✓ Тохижилт ногоон байгууламж хариуцсан ажилтан
- ✓ Нярав

Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолоор аймгийн захиргааны удирдлагын бүтцийг батлахдаа аймгийн Засаг даргын орлогч 1 (2022 оны 7 дугаар сараас) байхаар тогтоосон байхад 2024 онд 2 орлогч томилон ажиллаж байна.

Цогт сум 2023 оны 02 дугаар сараас эхлэн сумын Засаг даргын 2 орлогч томилон ажиллуулж байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5.2<sup>7</sup>-д заасан заалтыг зөрчсөн байна.

Аймгийн хэмжээнд төрийн улс төрийн алба болон төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт баталж мөрдүүлээгүй байна.

Аймгийн хэмжээнд 12 төрийн захиргааны албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтыг хянуулахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн боловч одоогоор хариу ирээгүй байна. Үүнд:

- ✓ Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 1,
- ✓ Эрүүл мэндийн газрын 7,
- ✓ Байгаль орчны газрын 4.

Аймгийн хэмжээнд байгууллагын дарга нар өөрийн эрхлэх асуудлын хүрээнд албан тушаалын томилгоо хийхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг

<sup>7</sup> 5.2.Нийслэлийн Засаг дарга хоёр, аймаг, дүүрэг, сумын Засаг дарга нэгээс илүү орлогч даргатай байхыг хориглоно.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

Гэвч орон нутгийн нэмэгдэл олгох хувь хэмжээг харилцан адилгүй тогтоосон, зарим төрийн албан хаагчид ч тус нэмэгдлийг олгожгүй байна.

Орон нутагт ажиллаж буй төрийн захиргааны албан хаагчид таван жил тутам урамшуулал олгох хууль, эрх зүйн орчин бүрдсэнээр тайлант онд 296 төрийн албан хаагчид 2,082.1 сая төгрөгийн урамшуулал олгосон байна. Тус урамшууллыг олгохдоо төрийн байгууллагууд ХХОАТ суутгаагүй, цалингийн дунджийг буруу тооцоолсон байна.

Төрийн албан хаагчид 7 төрлийн нөхөх төлбөр авах эрх зүйн зохицуулалтай боловч одоогоор зөвхөн албан томилолтын нөхөх төлбөр олгогдож бусад төрлийн нөхөх төлбөрийг олгодоггүй байна.

Төрийн албан хаагчдад олгож буй хоолны хөнгөлөлтийн судалгаа хийхэд хоногт 2,000.0-20,000.0 төгрөгийн хоолны хөнгөлөлт олгож байгаа нь харилцан адилгүй байна.

Нэг аймаг, орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагчдад харилцан адилгүй хөнгөлөлт, урамшуулал олгож байгаа асуудлыг орон нутгийн хэмжээнд тэгш, хүртээмжтэй болгох нэгдсэн шийдэл гаргах хэрэгцээ шаардлага байна.

### Илрүүлэлт:

-Төрийн захиргааны албан хаагчид 2.5 сая төгрөгийн зэрэг дэвийн нэмэгдэл илүү тооцож олгосон,

-Орон нутгаас хуваарилсан 21.1 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг ажиллаасдад олгосгүй,

-Үндсэн орон тооны бус ажилтанд 0.3 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдэл олгосон,

-Ажиллаасдад орон нутгийн нэмэгдэл олгохдоо 0.3 сая төгрөг дутуу, 1.2 сая төгрөг илүү тооцож олгосон,

-Сумын ЗДТТ-ын Мал, аж ахуйн үйлдвэрлэл, төлөөлөлт, менежмент, малын үржил бүртгэл хариуцсан мэргэжилтэн албан тушаалын зэрэглэлийг үзэхэд цалин зөрүүтэй тогтоосноос 6.2 сая төгрөг илүү олгосон,

-Ажиллаасдад төрийн албан хаасан хуваараны нэмэгдэл олгохдоо 0.3 сая төгрөг дутуу, 5.5 сая төгрөг илүү олгосон,

-Төрийн захиргааны албан хаагчдад 6 жилийн урамшууллаас 49 байгууллага 192.3 сая төгрөгийн ХХОАТ суутгаагүй, шилжүүлээгүй, 4 байгууллага 0.4 сая төгрөгийн ХХОАТ илүү тооцож шилжүүлсэн,

-Төрийн захиргааны албан хаагчдад 5 жилийн урамшууллыг 50 байгууллага 149.2 сая төгрөгөөр илүү, 7 байгууллага 25.1 сая төгрөг дутуу тус тус тооцож олгосон.

### 1.3.3 Төрийн байгууллагуудад гарсан сул орон тоог хууль болон холбогдох журмын дагуу олон нийтэд ил тод мэдээлж, нөхөн томилж байна уу?


Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1<sup>10</sup>-д заасан эрх бүхий этгээд дараах журмын дагуу нөхөн томилгохоор тусгасан байна.

- ✓ Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс,
- ✓ Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас,
- ✓ Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоог тухайн байгууллагад ажиллаж байгаа албан хаагчдаас нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс,

<sup>10</sup> 27.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилж эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1<sup>8</sup>-т заасан хориглолт хязгаарлалтыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.



### 1.3.1 Эрх бүхий байгууллагаас төрийн байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, албан тушаалын давхардал, хийдлийг арилгах арга хэмжээ авч байна уу?

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт аймаг, сумын ЗДТГ, харьяа агентлаг төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна. Сүүлийн 10 жилд аймгийн хүн ам 8.2 хувиар өссөн, нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчит газруудын тоо нэмэгдэж байгаа боловч томоохон үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлд ахиц дэвшил гараагүй нь чиг үүргийг зөв зохистой хуваарилах, оновчтой бүтэц бий болгох бодлогын арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлага үүссэн байгааг илтгэж байна.

### 1.3.2 Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаагаар хангаж байна уу?

Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлд<sup>9</sup> заасны дагуу төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох харилцааг зохицуулсан.

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагуудад албан тушаалын тодорхойлолтын дагуу эрхэлсэн түшмэл 2, ахлах түшмэл 68, дэс түшмэл 524, туслах түшмэл 9 нийт 605 төрийн захиргааны албан хаагч ажиллаж байна. Үүний 401 нь өөрийн эрхэлж буй албан тушаалын дагуу зэрэг дэвийн нэмэгдэл авах шалгуур шаардлагыг ханган зэрэг дэвийн нэмэгдэл авч байна.

Сүүлийн жилүүдэд Засгийн газраас төвлөрлийг сааруулах, орон нутагт ажиллах иргэдийг бодлогоор дэмжих арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлсний үр дүнд 2023 оноос орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагчдын тодорхой хэсэг орон нутгийн нэмэгдэл авах эрх зүйн орчин бүрдэн хэрэгжиж байна. Энэ дагуу 2023 онд 1,571.3 сая төгрөг, 2024 онд 2,831.4 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдэл олгосон байна.

<sup>8</sup> 11.1"Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно"

<sup>9</sup> 21.1.Төрийн захиргааны тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэл, ахлах түшмэл, дэс түшмэл, туслах түшмэлийн албан тушаал нь тус бүртээ тэргүүн зэрэг, дэд зэрэг, гутгаар зэрэг, дөтгөөр зэрэг гэсэн зэрэг дэвтэй байна.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

Дээрх байдлаар тухайн албан тушаалд гарсан сул орон тоог нөхөх боломжгүй тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2<sup>11</sup>-д заасны дагуу эрх бүхий байгууллага, олон нийтэд мэдээлэх үүрэгтэй бөгөөд тухайн долоо хоногт сул орон тооны талаар мэдээлж, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох байгууллагад хүргүүлнэ гэж заажээ.

Төрийн байгууллагад сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагууд өөрийн цахим сүлжээ, сайтад байршуулан зарлан мэдээлдэг байсан бөгөөд 2022 онд ХНУМТ цахим систем шинэчлэгдсэнээс хойш сул орон тооны зарыг цахимаар мэдээлдэг болсон байна.

Аймаг дахь ТАЗ-ын салбар зөвлөлд 2022-2023 онд 399 сул орон тооны захиалгыг төрийн байгууллагууд мэдээлж, шалгалтад тэнцэн хамгийн өндөр оноо авсан иргэдийг нэр дэвшүүлж сул орон тоог нөхөн томилсон байна. Үүнд:

- ✓ 2022 онд давхардсан тоогоор 138 орон тоо,
- ✓ 2023 онд давхардсан тоогоор 261 орон тоо,

Сул орон тоо нөхөгдөөгүй шалтгаан нь тухайн ажлын байранд тавигдах шаардлага хангасан иргэн хүсэлт гаргаагүй, бүртгүүлсэн иргэд шалгуур хангаагүйгээс дахин зарлах нөхцөл үүссээр байна.

Аймгийн ИТХ, ЗДТГ, Эрүүл мэндийн газрын сул орон тоонд төрийн албаны тусгай шалгалт өгч томилогдсон 14 албан хаагч тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангахгүй байгаа боловч төрийн албаны тусгай шалгалт өгөхөөр бүртгүүлсэн иргэдээс 2022 онд 14, 2023 оны эхний хагас жилд 45 иргэнийг тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлага хангаагүй, материал дутуу ирүүлсэн шалтгаанаар бүртгэлээс хассан байна.

Төрийн захиргааны 35 байгууллагын 93 төрийн жинхэнэ албан тушаал, 14 байгууллагын 71 төрийн үйлчилгээний нийт 164 сул орон тоо байна.

Төрийн захиргааны 5 байгууллагын 7 албан тушаалын тодорхойлолт батлагдаагүйгээс сул орон тоог нийтэд зарлах боломжгүй, бусад 86 орон тооноос 69 сул орон тоог нийтэд мэдээлсэн, 8 байгууллагын 17 албан тушаалыг нийтэд зарлан мэдээлээгүй байна.

Аймаг дахь ТАЗ төрийн байгууллагуудаас сул орон тооны мэдээллийг улирал тутам авч нэгтгэх ажлыг зохион байгуулснаар тодорхой ахиц гарсан боловч сул орон тоог нийтэд зарлахгүй байх, хууль зөрчин түр томилгоо хийсний дараа зөрчлийг арилгах арга хэмжээ авч байгаа байдал нийтлэг бий болсон байна. Тухайлбал: Төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй 82 иргэнийг төрийн захиргааны албан тушаалд томилсон байна.

Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарт сумын их эмч 11, бага эмч 23 дутагдалтай байгаа нь бага эмчийн мэргэжил олгохгүй болсонтой холбоотой байна.

Боловсролын салбарт хийсэн судалгаагаар ирэх 3 жилд хими, англи хэл, дуу хөгжмийн мэргэжлийн багшийн дутагдал бий болох тооцоо гарсан байна.

Засгийн газраас зохион байгуулсан "Шүүр" ажиллагааны хүрээнд илэрсэн зөрчлийг арилгасан байдлыг үзэхэд зөрчилтэй томилгоотой албан тушаалтныг ажлаас чөлөөлсөн шийдвэрээ аймгийн Засаг дарга цуцалж, буцаан тухайн албан тушаалд томилсон байна. Мөн харьяа байгууллагууд дээрх зарчмын дагуу шийдвэрлэсэн нь тус ажиллагааны үр нөлөөг бууруулж, зөрчлийг шат шатандаа арилгаагүй байна. Тухайлбал:

<sup>11</sup> 27.2.Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

## Хүснэгт №.8. Хүчингүй болгосон захирамж

№	Захирамжийн огноо, дугаар	Товч утга, агуулга	Албан тушаал
1	2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн Б/36	Шүүр ажиллагааны хүрээнд ажлаас чөлөөлөх тухай	СХДАА-ны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
2	2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн Б/37	Шүүр ажиллагааны хүрээнд ажлаас чөлөөлөх тухай	ГХБХБГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
3	2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн Б/38	Шүүр ажиллагааны хүрээнд ажлаас чөлөөлөх тухай	БОАЖГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
4	2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн Б/39	Шүүр ажиллагааны хүрээнд ажлаас чөлөөлөх тухай	Насан туршийн боловсролын төвийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
5	2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн Б/44	2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн Б/36, Б/37, Б/39 захирамж хүчингүй болгох тухай	

Тус ажиллагааны хүрээнд илэрсэн 22 байгууллагын 66 томилгоотой холбоотой зөрчлийн 31 нь арилаагүй байна.

### Илрүүлэлт:

-Төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй 82 иргэнийг төрийн захиргааны албан тушаалд томилсон,  
-Тухайн албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил зөрүүтэй 112 албан хаагч ажиллаж байгаа бол өмнөх онуудад мэргэшил зөрүүтэй 69 албан хаагч ажилласан байна,  
-Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжил зөрүүтэй 4 албан хаагч ажиллаж байна.

**Дүгнэлт:** Төрийн байгууллагад гарсан сул орон тоог холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зарлаж нээлттэй, шударга зарчмаар сонгон шалгаруулалт зохион байгуулах шаардлагатай байна.

### 1.3.4 Төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж, төрд хохирол учруулсан байна уу?

Төрийн албан хаагчийг хууль бусаар чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг эрх бүхий байгууллагаас тогтоож, төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1<sup>12</sup>, 50.2<sup>13</sup>-т нарийвчлан тусгажээ.

Мөн тус хуулийн шинэчилсэн найруулгаар төрийн албан тушаалд сонгон шалгаруулалтгүйгээр томилогдсон иргэн, албан хаагчийг албан тушаалаас чөлөөлсөн шийдвэр гаргаагүй тохиолдолд хууль бусаар томилсон гэж үзэж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш олгосон цалин хөлс, нэмэгдлийг төрд учруулсан хохиролд тооцохоор зохицуулсан байна.

Нийт 107 албан хаагчтай холбоотой 957.5 сая төгрөгийн цалингийн нөхөн олговрыг 2016-2023 онд төсвөөс олгосон байна. Үүнээс 31 хариуцагч буруутай этгээдээр төсвөөс олгосон нөхөн олговрыг төлүүлэхээр хуулийн байгууллагад нэхэмжлэл гаргаснаас 127.4 сая төгрөгийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож 40.7 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэжээ.

<sup>12</sup> 50.1.Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.

<sup>13</sup> 50.2.Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана.

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

Төрийн аудитын байгууллагаас жил бүр санхүүгийн тайлангийн аудитаар төсвөөс олгосон цалингийн нөхөн олговрыг төлүүлэхээр аудитын шийдвэр өгч байгаа боловч тус хохирлыг барагдуулах талаар төсөв захирагчид тодорхой арга хэмжээг зохион байгуулахгүй байна.


Цаашид төрд учруулсан хохирлыг төлүүлэх ажлыг эрчимжүүлж, томилох эрх бүхий албан тушаалтан төрд хохирол учруулах аливаа шийдвэр гаргахгүй байх, үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж хуулийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байна.

**Дүгнэлт:** Төрд учруулсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулж, эрчимжүүлэх шаардлагатай байна.

### 1.3.5 Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрэн бүрдүүлж, үр дүнтэй ашиглаж байна уу?

ТАЗ-өөс төрийн бүх байгууллагыг хамарсан төрийн албаны хүний нөөцийн системийг 2022 онд "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим систем нэртэйгээр шинэчлэн баталжээ. Тус системд төрийн албан хаагчийн талаарх дараах мэдээлэл агуулагдаж байна.

Дүрслэл №1. Хүний нөөцийн программын бүтэц



Энэхүү системд ТАЦНС-тэй мэдээлэл солилцох тохируулга хийгдсэн байна. Аймгийн төрийн захиргааны байгууллагууд төрийн албан хаагчдын тоо, хүний нөөцийн мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) системээр хийж мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна.

Гэвч зарим байгууллагын албан тушаалын нэршил тус системд байхгүйгээс тухайн албан тушаалын үндсэн цалинтай дүйцэх өөр албан тушаалын нэршилээр мэдээлэл оруулж байна.

#### Илрүүлэлт:

- Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын хэрэгжилтийг түүвэрлэн үзэхэд хувийн хэргийн бүрдүүлэлт хангалтгүй байна.

## 2.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТОЛЦОО НЬ САЙН ЗАСАГЛАЛЫГ БИЙ БОЛГОЖ БАЙНА УУ?

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогод иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ гэж заасан байна.

Тус бодлогыг 3 үе шаттай хэрэгжүүлэх ба чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлэх, нийгмийн хөгжлийг дэмжсэн, үр нөлөөтэй, цомхон төрийн албыг төлөвшүүлж, төрийн үйлчилгээний менежментийг олон Улсын түвшинд хэрэгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

"Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт "Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжүүлэх", 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын баримт бичигт "Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн хүнд суртлыг бууруулах" зорилт арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган, энэ талаар бусад дунд богино хугацааны хөгжлийн баримт бичигт хэрэгжүүлэх арга

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

хэмжээнүүд үе шаттайгаар тусгагдан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

## 2.1 Иргэндээ үйлчилдэг мэргэшсэн, чадварлаг илт тод төрийн алба төлөвшсөн байна уу?

Төрийн албыг мэргэшсэн чадварлаг болгох зорилгоор албан хаагчдыг тасралтгүй сургах, албан хаагчийн ажлын туршлага, мэргэшсэн байдал, мэргэжлийн онцлогийг харгалзан сэлгэн, шилжүүлэн ажиллуулах зэргээр бодлогоор дэмжих эрх зүйн орчин бүрдсэн байна.

### 2.1.1 Төрийн албан хаагчдыг орон зайнаас үл хамааруулан сургаж байна уу?

Төрийн албаны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1<sup>14</sup>-д заасны дагуу мэргэшүүлэх сургалтын агуулга, хөтөлбөрийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тодорхойлохыг хуульчилсан байна.

Мөн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2<sup>15</sup>-т заасны дагуу тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдохын тулд ажилласан жилийн шаардлагаас гадна мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх тусгай шаардлага тавигдсан. Үүнд: Засгийн газрын 2023 оны 90 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж албан тушаалын тусгай шаардлагад тавигдсан зарим нөхцөлийг бууруулсан байна.

Төрийн албан хаагчийн сургалтын талаарх хууль тогтоомжид заасны дагуу анх төрийн албанд томилогдсон иргэнийг 40 цагийн чиглүүлэх, 1 жил хүртэлх хугацаанд мэргэшүүлэх, дунд хугацааны сургалтад хамруулах, 3 жил тутамд мэргэшүүлэх давтан сургалтад хамруулах, түүнчлэн хэрэгцээ, шаардлагаар богино хугацааны зорилтот сургалтад тухай бүр хамруулах төрийн албан тушаалын ахлах, эрхэлсэн, тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд томилогдоход мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байх шаардлага тавигдсан.

Албан тушаалын ангилал, зэрэглэл, чиг үүргийн онцлогт тохирсон үе шаттай, сургалтын тогтолцоог төлөвшүүлэх, чадавжуулахыг бодлого чиглэлдээ тусган хэрэгжүүлж байна.

ЗГХЭГ-ын дарга, ТАЗ-ийн даргын хамтарсан 2019 оны 37/33 дугаар тушаалаар "Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр"-ийг баталжээ.

Төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн ангилалд хамаарах албан тушаал хашиж байгаа албан хаагчдыг мэргэшүүлэх сургалтад 2019-2024 эхний хагас жилийн байдлаар 164 албан хаагч хамрагдаж, төгссөн. Одоо нийт 66 албан хаагч суралцаж байна.

